



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

*Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит*

Аудитын код: *ДОА-2021/55/СТА-ТШЗ*

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Дэлгэрмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: delgermaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар



Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	11
3.4. Материаллаг байдал	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Залруулсан алдаа.....	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	14
Аудитын зөвлөмж.....	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	15
4. Менежментийн захидал.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	16



1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.23 № 119

танай _____-ны № _____-т

Г ХАЛХГОЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
А.ЭНХЖАРГАЛ ТАНАА

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Халхгол сумын Засаг даргын тамгын газар 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 94.0 хувийн биелэлттэй дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

011020070



Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний ҮЛДЭГДЭЛ	Эцсийн ҮЛДЭГДЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	280588012.00	275688878.00
33	АВЛАГА	15200000.00	6500000.00
335	Бусад авлага	15200000.00	6500000.00
3351	Байгууллагаас авах авлага	15200000.00	6500000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	265388012.00	269188878.00
351	Түүхий эд материал	627500.00	1488600.00
35110	Тусгай зориулалттай материал	627500.00	1488600.00
354	Хангамжийн материал	59176794.00	62116560.00
35410	Бичиг хэргийн материал	75000.00	103000.00
35420	Аж ахуйн материал	55351794.00	57263560.00
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	1000000.00
35470	Бусад хангамжийн материал	3750000.00	3750000.00
35600	Мал амьтад	205583718.00	205583718.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	11940834797.26	3718133388.35
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	11940834797.26	3718133388.35
392	Биет хөрөнгө	11811724445.70	3710039185.08
39201	Барилга, байгууламж, орон сууц	2534503357.03	2558515089.03
39202	Хуримтлагдсан элэгдэл	-131329673.66	-198383251.25
39203	Авто-тээврийн хэрэгсэл	149396082.00	266867379.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-124899548.64	-156045845.85
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	188154164.11	199220653.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-85433582.09	-71020991.48
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	137008947.33	170619924.33
39208	Хуримтлагдсан элэгдэл	-74742080.87	-63232531.27
39209	Зам, гүүрийн байгууламж	306496880.00	306496880.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-153880642.58	-167577741.62
39214	Бусад үндсэн хөрөнгө	9937231579.00	1364465596.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-870781035.93	-499885974.81
393	Биет бус хөрөнгө	129110351.56	8094203.27
39301	Програм хангамж	173134200.00	2467200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-51175048.44	-1524196.73
39303	Бусад биет бус хөрөнгө	7151200.00	7151200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	12221422809.26	3993822266.35
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	12221422809.26	3993822266.35
51	Засгийн газрын хувь оролцоо	12221422809.26	3993822266.35
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1421673069.39	1421673069.39
51101	Өмч: - төрийн	1421673069.39	1421673069.39
512	Хуримтлагдсан үр дүн	10125546015.15	1897945472.24
51210	Өмнөх үеийн үр дүн	265585790.89	10116846015.15
51220	Тайлант үеийн үр дүн	9859960224.26	-8218900542.91
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	674203724.72	674203724.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	12221422809.27	3993822266.35



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	10662261747.97	1171825937.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10020152995.97	678886340.50
120	Нийтлэг татварын бус орлого	10020152995.97	678886340.50
120004	Төсөв байгууллаагын өөрийн орлого	10020152995.97	678886340.50
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10020152995.97	678886340.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	642108752.00	492939597.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	469629300.00	434148600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	469629300.00	434148600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	172479452.00	58790997.00
131103	ЗГНХ, ЗДНХ өрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн	19129422.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн	151126433.00	37636997.00
131105	Төсвийн байгууллаагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2223597.00	21154000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	802301523.71	996845086.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	802301523.71	996845086.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	784320331.71	972676387.73
2101	Цалин хөдс болон нэмэгдэл урамшил	225731879.00	274549076.00
210101	Үндсэн цалин	221683879.00	264519700.00
210104	Урамшуулал	4048000.00	10029376.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27687948.00	34225571.00
210201	Тэтгэврийн даатгал	19020701.74	23636771.00
210202	Тэтгэмжийн даатгал	2237729.67	2647300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1739138.33	2117700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	426398.02	529700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4263980.24	5294100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20230651.00	19013280.00
210301	Гэрэл, цахилгаан	6900397.00	4482880.00
210302	Түлш, халаалт	13330254.00	14134400.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	396000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	60141947.00	48267208.00
210401	Бичиг хэрэг	3415100.00	3303100.00
210402	Тээвэр, шатахуун	51463847.00	27495971.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4760000.00	2255000.00
210404	Ном, хэвлэл	503000.00	615000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	459000.00
210408	Бараа материал акалсны зардал	0.00	14139137.00
2105	Нормативт зардал	300000.00	321650.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300000.00	321650.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11235610.00	1000000.00
210601	Багаж, техник хэрэгсэл	228010.00	0.00
210604	Урсгал засвар	11007600.00	1000000.00
2107	Томилолт, зочны зардал	26341000.00	8334700.00
210702	Дотоод албан томилолт	16341000.00	6334700.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	10000000.00	2000000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	946000.00	3243500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	1448400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	420000.00	600000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	79500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	248300.00	815900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132000.00	154000.00
210807	Газрын төлбөр	145700.00	145700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	411705296.71	583721402.73
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	152420447.01	86668650.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	259284849.70	497052752.73
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17981192.00	24168699.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	17981192.00	24168699.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	17981192.00	24168699.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	9859960224.26	174980850.77
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	8393881393.68
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	8393881393.68
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	-8393881393.68
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	9859960224.26	-8218900542.91



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	642108752.00	492939597.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	642108752.00	492939597.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	469629300.00	434148600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	469629300.00	434148600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	172479452.00	58790997.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн	19129422.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн	151126433.00	37636997.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2223597.00	21154000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	642108752.00	492939597.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	642108752.00	492939597.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	624127560.00	468770898.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	219208967.00	274549076.00
210101	Үндсэн цалин	215160967.00	264519700.00
210104	Урамшуулал	4048000.00	10029376.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30735000.00	34225571.00
210201	Тэтгэврийн даатгал	20489800.00	23636771.00
210202	Тэтгэмжийн даатгал	2561300.00	2647300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2049000.00	2117700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	512300.00	529700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5122600.00	5294100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21523897.00	19013280.00
210301	Гэрэл, цахилгаан	6900397.00	4482880.00
210302	Түлш, халаалт	14623500.00	14134400.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	396000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	61216947.00	34128071.00
210401	Бичиг хэрэг	3490100.00	3303100.00
210402	Тээвэр, шатахуун	51463847.00	27495971.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5760000.00	2255000.00
210404	Ном, хэвлэл	503000.00	615000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	459000.00
2105	Нормативт зардал	300000.00	1021650.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300000.00	1021650.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29744600.00	5620000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9684000.00	3620000.00
210602	Тавилга	8500000.00	0.00
210604	Урсгал засвар	11560600.00	2000000.00
2107	Томилолт, зочны зардал	26341000.00	8334700.00
210702	Дотоод албан томилолт	16341000.00	6334700.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	10000000.00	2000000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1878200.00	3243500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	1448400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	420000.00	600000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	79500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	248300.00	815900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132000.00	154000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	932200.00	0.00
210807	Газрын төлбөр	145700.00	145700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	233178949.00	88635050.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	233178949.00	88635050.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17981192.00	24168699.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	17981192.00	24168699.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	17981192.00	24168699.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,421,673,069.39	674,203,724.72	267,385,790.89	2,363,262,585.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-1,800,000.00	-1,800,000.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,421,673,069.39	674,203,724.72	265,585,790.89	2,361,462,585.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	9,859,960,224.26	9,859,960,224.26
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,421,673,069.39	674,203,724.72	10,125,546,015.15	12,221,422,809.26
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,421,673,069.39	674,203,724.72	10,125,546,015.15	12,221,422,809.26
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-8,700,000.00	-8,700,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,421,673,069.39	674,203,724.72	10,116,846,015.15	12,212,722,809.26
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-8,218,900,542.91	-8,218,900,542.91
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,421,673,069.39	674,203,724.72	1,897,945,472.24	3,993,822,266.35



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	454748600.00	430683901.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	454748600.00	430683901.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	454748600.00	430683901.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	264719700.00	264519700.00
210101	Үндсэн цалин	264719700.00	264519700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35737000.00	34225571.00
210201	Тэтгэврийн даатгал	25148200.00	23636771.00
210202	Тэтгэмжийн даатгал	2647300.00	2647300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2117700.00	2117700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	529700.00	529700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5294100.00	5294100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19209000.00	19013280.00
210301	Гэрэл, цахилгаан	4678600.00	4482880.00
210302	Түлш, халаалт	14134400.00	14134400.00
210303	Цэвэр, бохир ус	396000.00	396000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31495100.00	31374100.00
210401	Бичиг хэрэг	3248100.00	3248100.00
210402	Тээвэр, шатахуун	24877000.00	24877000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2175000.00	2175000.00
210404	Ном, хэвлэл	695000.00	615000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500000.00	459000.00
2105	Нормативт зардал	1600000.00	1021650.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1600000.00	1021650.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5620000.00	5620000.00
210601	Багаж, техник хэрэгсэл	3620000.00	3620000.00
210604	Урсгал засвар	2000000.00	2000000.00
2107	Томилолт, зочны зардал	8134700.00	8134700.00
210702	Дотоод албан томилолт	6134700.00	6134700.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2000000.00	2000000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21795100.00	1795100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20000000.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600000.00	600000.00
210803	Даатгалын үйлчилгээ	79500.00	79500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	815900.00	815900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	154000.00	154000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	0.00
210807	Газрын төлбөр	145700.00	145700.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	66438000.00	64979800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	66438000.00	64979800.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	454748600.00	454852600.00
1310	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	362076200.00	362076200.00
131001	Орон нутгийн төсвөөс санхүүжих	362076200.00	362076200.00
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	92672400.00	92776400.00
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600000.00	704000.00
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	92072400.00	92072400.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	28.00	28.00
620001	Удирдах ажилтан	6.0	6.0
620002	Гүйцэтгэх ажилтан	15.0	15.0
620003	Үйлчлэх ажилтан	7.0	7.0
620004	Гэрээт ажилтан	0.0	0.0



2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	172479452.00	38086997.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	172479452.00	38086997.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	172479452.00	38086997.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4048000.00	10029376.00
210104	Урамшуулал	4048000.00	10029376.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1767597.00	0.00
210301	Гэрэл, цахилгаан	1767597.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	2308747.00	2753971.00
210401	Бичиг хэрэг	456000.00	55000.00
210402	Тээвэр, шатахуун	1852747.00	2618971.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	80000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	602000.00	0.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	602000.00	
2107	Томилолт, зочны зардал	897000.00	200000.00
210702	Дотоод албан томилолт	897000.00	200000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	1448400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	1448400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	162856108.00	23655250.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	162856108.00	23655250.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	172479452.00	38086997.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	172479452.00	38086997.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	170255855.00	37636997.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2223597.00	450000.00



3. Аудитын тайлан

3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дүгнэлтийг А.Энхжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 18-ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Дэлгэрмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Халхгол сумын Засаг даргын тамгын газар 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 03/51 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

Халхгол сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- “Төрийн үйлчилгээг ард иргэдэд түргэн шуурхай хүргэх”

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Халхгол сумын Засаг даргын тамгын газар санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас 2020 онд Халхгол сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, нийт 121,206.4 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 1,336.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 75,514.8 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 44,355.6 мянган төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж өгсөн байна.

Өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг 2020.12.14-ний өдрийн 2/549 тоот албан бичгээр хүргүүлж ажилласан байна.



3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 996,845.1 төгрөгөөс 2 хувиар тооцон 19,936.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,227,600.5 мянган төгрөгөөр буюу 32.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	15,200.0	6,500.0	-8,700.0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	265,388.0	269,188.9	3,800.9
Үндсэн хөрөнгө	11,940,834.8	3,718,133.4	-8,222,701.4
Нийт хөрөнгө	12,221,422.8	3,993,822.3	-8,227,600.5
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	12,221,422.8	3,993,822.3	-8,227,600.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	12,221,422.8	3,993,822.3	-8,227,600.5

Авлага дансны үлдэгдэл 6,500.0 мянган төгрөг болж 8,700.0 мянган төгрөгөөр буурсан нь урд оны авлага барагдуулсантай холбоотой байна. Авлага дансны үлдэгдэлд 2018 онд үүссэн автомашины акт болох 15,000.0 мянган төгрөгийн байгууллагаас авах авлагын үлдэгдэл бөгөөд одоогийн байдлаар шүүхийн шатанд хэлэлцэж байгаа, шийдвэрлэгдээгүй авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 180,428.9 мянган төгрөг болж 642.2 мянган төгрөгөөр өссөн нь нөөцийн материал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,718,133.4 мянган төгрөг болж 8,222,701.4 мянган төгрөгөөр буурсан нь Шинэ сумын нийтийн эзэмшил, ариун цэврийн байгууламжийг “Халхгол нэгдэл” ОНӨААТҮГ-ын дансанд шилжүүлснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь хөрөнгө оруулалтаар 471,590.8 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 4,463.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 220,414.6 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 8,581,745.2 мянган төгрөг, акталсан 671,995.6 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.



Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,444,906.4 мянган төгрөг болж 292,234.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант жилд суманд хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудын орлого нь элэгдлийн зардлаас их байгаагаас шалтгаалсан байна

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,993,822.3 мянган төгрөг болж 8,227,600.5 мянган төгрөгөөр буурсан нь “Халхгол нэгдэл” ОНӨААТҮГ-т шилжүүлсэн үндсэн хөрөнгө хассаны гарз үүссэнээс шалтгаалжээ.

Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 9,490,435.8 мянган төгрөгөөр буюу 89.0 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 678,886.3 мянган төгрөгийн орлого байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өмнөх оноос нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 194,543.6 мянган төгрөгөөр буюу 24.0 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал байна. Энэ нь үндсэн хөрөнгийг элэгдэлтэй нь хамт шилжүүлснээс үүссэн зардал байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 705,595.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 705,595 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 250,846.4 мянган төгрөгөөр бууруулж 454,748.6 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь Засаг даргын нөөцийн сангийн хөрөнгө оруулалтын зардалд төлөвлөсөн санхүүжилт батлагдаж ирээгүйтэй холбоотой.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 454,748.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 434,148.6 мянган төгрөгийг улсын төсвөөс 20,600.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 434,148.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 20,704.0 мянган төгрөг, нийт 454,748.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 430,579.9 мянган төгрөгийг зарцуулж 24,168.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 430,579.9 мянган төгрөг буюу 94.7 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 200.0 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын зардлыг 1,511.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх 20,000.0 мянган төгрөг, бусад зардалд 2,353.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.



Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого

Орон нутгийн төсөвт 2020 онд 600.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 704.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 117.0 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2 Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
Төсөвт байгууллагын өөрийн орлого	600.0	704.0	104.0	117.0
Нийт дүн	600.0	704.0	104.0	117.0

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 37,637.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 450.0 мянган төгрөг, нийт 38,087.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж бараа үйлчилгээний зардалд бүрэн зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 138 мэдээлэл, төсөв, мөнгөтэй холбоотой нөөцийн сангийн зардлын шийдвэрээс бусад шийдвэр мэдээлэгдээгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2.219.3 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 251,918.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 251,918.9 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт.

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	2,219.3	1	2,219.3	0.0	0.0	100
Албан шаардлага	1	251,918.9	1	251,918.9	0.0	0.0	100
Зөвлөмж	1	18,219.1	1	18,219.1	0.0	0.0	100
Нийт дүн		272,357.3		272,357.3	0.0	0.0	100



3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 113,958.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 106,931.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 7,027.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 527.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 6,500.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ.

Залруулсан алдаа

Үнэ төлбөргүй орлогодсон 106,931.0 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авснаар бүртгэснийг залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 7,027.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 527.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 6,500.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Засаг даргын захирамжаар 527.0 мянган төгрөгийг журамд хамаарахгүй, урьдчилан төлөвлөх боломжтой, нэг удаагийн бус шинж чанартай арга хэмжээнд зарцуулсан нь Сангийн Сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-ын 1.1, 1.2 дахь заалтыг зөрчсөн, үнэн зөв байдал, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Шилэн дансанд байршуулсан мэдээллийг ерөнхий журнал болон анхан шатны санхүүгийн мэдээ тайлангуудтай тулгахад төсөв, мөнгөтэй холбоотой нөөцийн сангийн зардлын шийдвэрээс бусад шийдвэр мэдээлэгдээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Засаг даргын захирамжаар 6500.0 мянган төгрөгийг журамд хамаарахгүй, урьдчилан төлөвлөх боломжтой, нэг удаагийн бус шинж чанартай арга хэмжээнд зарцуулсан нь Сангийн Сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-ын 1.1, 1.2 дахь заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Тайлант оны эцэст 6.5 сая төгрөгийн он дамжсан авлагатай байгаа бөгөөд шүүхийн шатанд шийдвэрлэгдээгүй байгааг дараагийн аудитад авч үзэх шаардлагатай байна.

4. Менежментийн захидал



Зөвлөмж өгөгдөөгүй.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			ДОА-2021/55/СТА-ТШЗ

Шалгагдсан байгууллагын нэр:	Халхгол сумын Засаг даргын тамгын газар	Мянган төгрөг
------------------------------	--	---------------

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Засаг даргын захирамжаар 527.0 мянган төгрөгийг журамд хамаарахгүй, урьдчилан төлөвлөх боломжтой, нэг удаагийн бус шинж чанартай арга хэмжээнд зарцуулсан.	527.0	Төлбөрийн акт	ЗДТГ-ын даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодогч	А.Энхжаргал М.Ариунзул
2	Төсөв, мөнгөтэй холбоотой нөөцийн сангийн зардлын шийдвэрээс бусад шийдвэр мэдээлэгдээгүй байна.	0.0	Албан шаардлага	ЗДТГ-ын даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодогч	А.Энхжаргал М.Ариунзул
3	Засаг даргын захирамжаар 6,500.0 мянган төгрөгийг журамд хамаарахгүй, урьдчилан төлөвлөх боломжтой, нэг удаагийн бус шинж чанартай арга хэмжээнд зарцуулсан байна.	6,500.0	Албан шаардлага	ЗДТГ-ын даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодогч	А.Энхжаргал М.Ариунзул
4	Үнэ төлбөргүй орлогодсон 106,931.0 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авснаар бүртгэснийг залруулав.	106,931.0	Алдааг засуулав.	ЗДТГ-ын даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодогч	А.Энхжаргал М.Ариунзул
ДҮН		113,958.0			

